

## МЕТАФИЗИК БАӨРНӨ ДОРНЫ СЭТГЭЛГЭЭНИЙ ЯЛГАА

Ж. Отгонсүрэн\*

Грекийн “мета” - “цаадах”, “дараа” гэсний дээрээс “*physis*”-ийг нэмж метафизик гэдэг үг үүсгэжээ. Анх энэ үгийг Аристотелийн бүтээлүүдэд гарчиг болгон ашиглахдаа, физикийн тухай бүлгийн дараа орох хэсэг гэсэн утгаар “*meta-* (“beyond”)” гэсэн үгийг нэмсэн гэдэг. Үнэндээ бол, Аристотель өөрийнхөө бүтээлийг “метафизик” гэж нэрлээгүй, харин “анхдагч философи” гэх саналтай байж. Харин Аристотелийн бүтээлийг хянан шүүсэн редактор Андроникус Роудэс, эхлээд философийн бүтээлүүд, дараа нь физикийнх гэсэн утгаар номын нэрээ /τ " μετ " τ " φυσικ " βιβλία (*ta meta ta physika biblia*) “физикийн номны дараах номнууд” гээд нэрлэчихэж. Үүнийг нь латин судлалын эрдэмтэд ташаа ойлгож, "the science of what is beyond the physical" буюу “биет зүйлсийн чанад дахь шинжлэх ухаан” гэж буулгаснаар метафизик<sup>1</sup> гэдэг нэр томъёо үүсч, түүнийгээ (*physis* in Greek) “байгалийн цаадах /дараах/ шинжлэх ухаан” өөрөөр хэлбэл материаллаг бусыг судлах гэж тайлбарлах болжээ.

Өрнийн сэтгэл судлалын онолоор хариулагдахгүй зүйлийн нэг нь метафизик гэгч ойлголт болой. Аристотелоос эхлээд өнөөг хүртэл сэтгэгчид, яруу найрагчдын бүтээлд ямагт далд өгүүлэгдэг, судлаачдыг эрэлд хатааж буй энэ ухагдахуун нь товчхондоо байгаль ертөнц дээр "байгаа гэхэд байхгүй ч юм шиг, байхгүй гэхихээр байгаад байдаг" тийм л зүйлийн тухай хэлээд байгаа аж. Жишээ нь, зүүдийг байхгүй гэж болохгүй, бас байгаа гэвэл бариад гаргаад ирж чадахгүй. Гэтэл зүүдээр дамжуулсан мэдээлэл илт оночтой байсныг барин тавин нотолдог.

Физикчид, байгальд эрчим хүч, энерги шинээр үүсч бий болдоггүй, орчлон ертөнц үүсэхэд тэр байж л байсан, харин түүнийг хувьсган, нэг төрлөөс нөгөөд хувирган өөрчилж болдог гэдэг. Түүнчлэн хайрыг мета үүднээс тайлбарлавал, Та түүнийг барьж, харж чадахгүй, харин мэдэрч л болно. Мэдрэгдэж байна гэдэг нь тэнд долгионы үелзэл /резонанс/ байна гэсэн үг. Тэрхүү долгион танд мэдээлэл дамжуулж байгаа хэрэг.

“Оршихуйн үлэмж дээд хэлбэрийг мэдрэх нь тайлбарлаж боломгүй, гүн нууцат тодорхой мэдрэмжтэй холбоотой. Түүнийг ямар нэг юмтай харьцуулах аргагүй, мөн сэтгэхүй хийгээд ургуулан бодохуйтай холбож болохгүй юм. Ийм мэдрэмж бол

\* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим, докторант

<sup>1)</sup> <http://en.wikipedia.org/wiki/Metaphysics>

бидний мэдрэхүй, хүртэхүй, сонсохуй, үнэрлэхүйд хүртэгдэх бүхнээс харьцангуй бодитой байдаг. Учир нь эдгээр мэдрэмж нь дээр дурьдсан дээд бодгалийн тодорхой мэдрэмжээс бусад мэдрэмжийг агуулдаг тул түүнийг эдгээрийн аль нэгтэй адилтгах боломжгүй”<sup>2</sup> гэж тантрын үндэст бичсэн байна.

Дорно дахинд метафизикийг дээрх байдлаар тайлбарлаж байна. Тэд оршихуйн дээд хэлбэрийг мэдрэх тухай л хэлснээс бус метафизик энэ тэр гэж нэрлэсэнгүй. Тэд угаасаа олон “изм” үүсгэж онол ярих дургүй, гагцхүү сэтгэлээ таньж дотоод руугаа хандахыг л эрхэмлэдэг. Тэндээс л ертөнцийн учрыг олно гэж үздэг.

Тэгвэл өрнөдийн алдарт сэтгэгч, далд судлалын онолч, аналитик шинжилгээний онолыг үндэслэгч Карл Густав Юнг “...дорно дахинд метафизикээс өөр өрнийнхний сэтгэл судлал /психологи/ -тай дүйцэх зүйл байхгүй. “mind” /сэтгэл санаа/ гэдэг үг дорно дахинд хэрэглэгдэхээрээ метафизик утгатай болчихдог” гэж хэлсэн нь сонирхолтой. Тэрээр цааш нь “өрнийн mind хэмээх ойлголт дундад зууны төгсгөлөөс метафизик тодотголоо гэж сэтгэцийн чиг үүргийг тэмдэглэдэг (psychic function) үг болчихсон. Бид “mind”-оюун санаа нь метафизик мөн чанартай гэдгийг, хувь хүний оюун санаа /“mind”/болоод таамаг орших ертөнцийн оюун ухаан /“universal mind”/ хоёр хоорондоо холбоотойг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхээр бидний сэтгэл судлал бол ямар нэгэн метафизик тодотголтгүй цэвэр сэтгэлийг судлах ухаан болж таарч байна”<sup>3</sup> гэсэн.

К.Г Юнгийн ийнхүү бичиж байх үед (1939 онд бичсэн хэдий ч бүүр сүүлд 1960-аад оноос л анхаарлын төвд орж ирсэн) өрнөдын сэтгэл судлалд З.Фройдг дагагсад, өрнийн сэтгэлгээг дорнынхоос доогуур тавьж, сэтгэлийн зүйлийг метафизик гэж тайбарласан Юнгийг “солиорсон” “мистицизмд донтогч” хэмээн тохуурхаж байсан түүхтэй.

К.Г Юнг: “өрнөдийн сэтгэл судлалд хүний оюун санаа “mind”-г ертөнцийн нэгдмэл шинжээс нь салгаж, тусдаа хүрээнд авч үзэж ирсэнээр хүн өөрөө сансар огторгуйн нэгэн хэсэг байхаа больж, хүний “anima “ -сэтгэл санаа нь ч ертөнцийн оюун санаа “anima mind”-аас үсэрсэн оч, хам чанар байхаа больсон”<sup>4</sup> гээд харин дорнын сэтгэлгээний хэлбэр одоогоор зөв гольдролоор яваа гэж тэмдэглэсэн . Тэрээр “өрнөд-ийн сэтгэлгээг экстраверсия-гадагшаа, дорнынхыг интроверсия –дотогшоо чиглэсэн загвар гэж тодорхойлсон байхад харин З.Фрөйд энэхүү интроверсия - дотогшоо хандлагыг хэвийн бус, оюун ухааны согогийн илрэл хэмээн авч үздэг байв.

Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүйг материалист сэтгэгчдийн давамгайлал буурч, мистикийг сонирхогчид, метафизикийг эрэлхийлэгчид тэргүүлэх болсоноор харуулж байх шиг. Өрнөдийн экстраверт сэтгэлгээний онолыг эргэн нягтлах цаг ирж, Юнгийн дэвшүүлсэн, дорнын интроверт сэтгэлгээг илүү судлах, дагаж хандлага эрчимжиж, илүү гүнд нь орж мэдрэсэнээ, тэндээс юу ойлгосноо өөрийнхөөрөө урлаг, уран сайхнаар илэрхийлсэн өвөрмөц илэрхийллийг таашаан дэмжих болсоныг өнөө цагийн тэргүүлэх зохиолчдын бүтээлээс харж болно. /Галлюцианизм бичсэн Хятадын зохиолч Мо Yan, Nobel-ийн шагнал авч, зэргэлдээ ертөнц хийгээд сэтгэхүйн мета үзэгдлийг өгүүлдэг Японы Мураками-ийг дараагийн Nobel-д уралдуулж байна./

<sup>2</sup> Буддын тантрын үндэс, (2012), Улаанбаатар, 6-7-р тал.

<sup>3</sup> К.Юнг, Бэлэгдэлт амьдрал, 375-р тал.

<sup>4</sup> К.Юнг, (1994), О психологий восточных религия и философии, Москва.

Дорно дахинд олон зууны өмнө соёолсон дотогш хандлагатай философи сэтгэлгээний эхлэлийг хөөвөл дор хаяж Будда багш Сидхарта Гаутама мэндэлсэн 2500 жилээс наашгүй яригдаж таарна. Гэтэл өнөөдрийн соёл иргэншил, хүн төрөлхтний хөгжлийг урагшлуулсан сэтгэлгээ бол яах аргагүй өрнийн сэтгэлгээ байсан. Гэтэл К.Г Юнг өөрийнхөө урган гарсан өрнийн сэтгэлгээг хатуугаар шүүмжилж, “Өрнөдийн шашинд хүний хийж чадах зүйл маш өчүүхэн, бүхнийг бурханд даатгадаг, харин **дорно дахинд хүн өөрөө бурхан, өөрөө өөрийгөө аврагч нь болчихдог** гэж тэмдэглээд, “дорнын оюуны арга барилаас нэг бүрчлэн суралцах хэрэгтэй, тэдний интроверт чиг хандлагыг ухамсаргүй unconscious-ээсээ хайвал дээр, “...өөртөө бурхангүй хүн гаднаас түүнийг олох ёстой болно. Заавал бурхан хайлгүйгээр өөрөө хөгжих чадвартай гэдгээ мэдэрсэн үед сэтгэл санааг гаднаас дүүргэх шаардлагагүй, хангалттай баялгийг өөртөө агуулдагаа ойлгосон цагт л дорно дахинаас суралцаж чадах юм<sup>5</sup> гэсэн байдаг.

#### **Метафизик ба Аюурзанын зохиолын далд өгүүлэмж**

Өрнийн алдарт сэтгэгч, мистик судлалын онолч, эрдэмтэн К.Г Юнгийн тодорхойлсон дорнын интроверт болон өрнийн экстраверт сэтгэлгээний жишээг тодорхой зохиолын дүрээр шинжих гээд үзье.

Уран зохиолын судлалд өвөрмөц нэгэн чиглэл болох психоанализ буюу сэтгэц задлагийн аргаар дүрийг шинжилнэ гэдэг товчхондоо, зохиолчийг сэтгэцийн хувьд эрүүл эсэхийг хянан магадлах, цаашлаад зохиолын гол баатруудын сэтгэцэд гарсан өөрчлөлтийг шинжилж шалгах маягийн юм хийнэ гэсэн үг<sup>6</sup> гэнэм. Нэгэнт сэтгэцийн эмчийн дэвшүүлсэн онолоор уран зохиолын сэтгэлгээг шүүх гэж байгаа болохоор судалгааны объект болох зохиолчийг, түүнчлэн зохиолын баатрыг өвчтөн гэж харах ёстой болдог. Тэгвэл, бид зохиолчийг сэтгэцийн өвчтэй эсэхийг хянан магадлах хэрэгтэй болох нь ээ? Тэгж зовж сууснаас, дорнын сэтгэлгээ талаасаа, зохиолын дүрийг шинжвэл, буддизмыг ойлгодог манай уншигчдад ч илүү дөхөм байх болов уу.

Ингээд зохиолч Г.Аюурзанын Шүгдэн романы хоёр залуу ламын үйлдэл, авир араншин хийгээд амьдралд хандах хандлагыг интроверт болон экстраверт сэтгэлгээний үүднээс тайлбарлах гээд үзье. Буддын ном, бурхны сургаальдаа үнэнч Саманд лам бол дотогшоо хандсан /дорнын интроверт/ сэтгэлгээний хэтийдсэн гэмээр жишээ юм. Хоёргүй үнэнчээр бурхны номыг дагаж, зөв сэтгэлийг баримталсаар ирсэн түүний хувь тавилан гэнэт гунигтайгаар төгсөх болсон тухай, нөгөө талд, үл ойлгогдох шалтгаанаар анд нөхрөө хороогоод, өөрийгөө мөн егүүтэж буй Дарамбал ламын үйлдэл, түүнчлэн хүний ертөнц хийгээд нөгөө ертөнц /тамын болон сүнсний/ -д өрнөх үйл явдал, урьд нас хийгээд үйлийн үрийн холбоо харилцан сүлэлдсэн, амархан тайлчихааргүй нарийн төвөгтэй орооцолдоон бүхий энэ роман нь үнэн чанартаа уншигчийг сэтгэцийн дотоод үзэгдэл, амьд явахын мөн чанарыг эргэцүүлэхэд хөтөлдөг.

Аливаа шинэлэг /өөр/ сэтгэлгээний бүтээлийг заавал нэг номлол, сургааль, “изм”-д хамруулан тайлбарлах нь уншигчийн ойлголт, төсөөллийг өөр зүгт залж, далд нууцлаг санааг өөрийнхөөрөө тайлах боломжийг үгүйсгэх мэт санагддаг тул энэ мэт оролдлогоос зайлсхийж, зохиолын дүр, дүрслэл, санааг нь бүхэлд нь дорнын интроверт хандлагын тодорхой жишээ гээд хэлчихмээр байна. Хэдийгээр бурхны

<sup>5</sup> Карл Густав Юнг (1994), “О психологии восточных религий и психологий”, Moscow.

<sup>6</sup> Г.Билгүүдэй. (2007), Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм, Улаанбаатар.

номд нэвтэрч, хоосон чанарыг таньсан хувраг хүнийх нь хувьд энэхүү хоёр залуу ламын дотоод руу өнгийж гэм нүгэл хийгээд, гэгээн ариун чанарыг нь илчлэн, буддын сэтгэлгээний үүднээс тайлбар зүүж болох боловч ингэх нь хэтэрхий албадмал болчих гэх шиг санагдах тул товчхон өгүүлсү.

"Гүмбум хийдэд гарсан хүн амины хэргийг мөрдөхөөр Ордосоос ирсэн мөрдөгч Сэржамцийн хуанди нэрт алдартай мөрч нохой ирсэн шөнөө учир битүүлгээр үхэж байгаа тэр хэсгээс эхлэн ээдрээт учралууд хөвөрнө. Талийгаач лам Дарамбалын гэрт үзлэг хийхэд олдсон ховор нандин судруудын завсарт хавчуулж үлдээсэн "Алуурчин нь хохирогчоосоо өмнө үхвэл тэр жинхэнэ аллага биш. Алуурчин хэдийнээ өөр төрөл авчихсан учраас тэр" гэсэн бичиг, ханан өлгөөстэй Доржшүгдэнгийн нууц шүтээн, орны хөндийгөөс олдсон "сонсгоод"судар... цагаан гарж нохой Шүгдэн сахиусын унаа, талийгаачийг хоног хураах өдөр нь Юшүд газар хөдөлжээ гэх цухас мэдээ..."<sup>7</sup> Энэ мэт үл ойлгогдох учрал тохиолууд уншигчийг гайхах, бодож эргэцүүлэх, цаашлаад Буддизм хийгээд сүсэг бишрэл, шүтэн барилдлагын учрыг тунгаан бясалгахад хүргэдэг. Энд мөнөөх Юнгийн хэлсэн дорнын сэтгэлгээний мета шинжийг ухаарах хэрэгтэй болно. Уг зохиолыг ердийн нэг детектив хэмээн хөнгөхөн уншаад өнгөрөх нэг хэрэг. Хэрхэн ойлгох нь уншигчийн зүгээс өөрийн дотоод гүнд шунгах чадвараас шалтгаална.

"Алчуурчин нь хохирогчоосоо урьдаж үхсэн бол тэр аллага биш"... Дарамбал буддын номонд муугүй суралцсан авьяаслах залуу хувраг боловч түүний сэтгэлийн хараа гадагшаа хандлага нь давамгайлж, өнгө мөнгөний шуналд хорлогдсон нэгэн. Анхдагч зорилго бол ном байсан боловч тэрээр, эгэл бусын эл замаасаа ямар ч үед үл хазайх өөрийн анд Самандын тууштай чанарт сэтгэлийнхээ гүнд атаархлын галыг өрдсөн үйлийн эцсийн үр нь ийм аж. /би ингэж ойлгосон /Атаархал бол сэтгэлийн гол гурван гэмийн нэг гэдгийг тэрээр мэдэхийн дээдээр мэднэ. Номын ухаан дутуугүй заяасан, суу заль дүүрэн тэрхүү залуу ламтанд нөхрийгөө хороон, өөрийгөө тонилгох хүртэл хорон үйлийг үйлдүүлэх ямархан нэгэн далдын хүч үйлчилсэн гэлтэй. Энд мөнөөх л, психоанализ талаас бол сэтгэцийн өөрчлөлт гэдгээр, харин дорнын ойлголтоор бол метафизик гэдгээр тайлбарлагдана.

Үүнээс цааш, Шүгдэн романы үг хэл, үйлдэл, түүний далдын утгыг хэрхэн тайлахыг уншигчдад өөрт нь үлдээсэн нь дээр гэж шийдлээ. Учир нь: *"уншигчийг өөрийг нь өөрөөр нь нээлгэх, нууц далд бүхнийг хатган сэрээх, удамшил зүйн буюу генетикийн замаар оюун тархинд нь дамжин ирсэн үнэт архитип-эх дүрсүүдийг өдөөн цочроож, хүнийг хөтлөх далд ухамсрын хүчин чадлыг мэдрүүлж өгөхүйц шинэ уран зохиол өнөөдөр хэрэгтэй байна"*<sup>8</sup> гэж профессор Ч.Билигсайханы тэртээ 2003 онд бичиж байсан тэр л санаа өнөөдөр хэдийнээ биелж, "шинэ уран зохиол" төрөөд эхэлчихсэн гэж үзэж байгаа юм.

Г.Аюурзанын зохиолын мета өгүүлэмж нь түүнийн зохиолын өнгөнд /tone/ агуулагдах далд илэрхийлэлд байдаг. Түүний бүтээлээс яруу тансаг хэллэгийг хайгаад хэрэггүй, харин өгүүлэмжийн дундуурх гүнзгий санааг хөөх нь илүү сонирхолтой. Түүний зохиолын хэл чамирхаж цэцэрхээгүй энгийн атлаа, эргэцүүлэх бодох зай завсар гаргахаас өөр аргагүй болдог. Хэрэв ингэхгүй бол ямархан нэгэн нууцыг анзааралгүй өнгөрөөчих мэт. Өөрөөр хэлбэл, түүний энгийн хэллэгт ямар нэгэн гүн утга агуулсан байдаг.

<sup>7</sup> Г.Аюурзана, (2012), "Шүгдэн", Улаанбаатар.

<sup>8</sup> Ч.Билигсайхан, (2003), "Ухаарахуй", 7-8-р тал.

Тэр тусмаа зохиолчийн дотоод ертөнцөд боловсорсон санаа, мета – өгүүлэмж нь, ертөнцийн мөн чанарыг танихыг хүссэн оюуны эрэлч - уншигчдыг эгэл сэтгэлгээнээс давсан оюун санааны төсөөлөлд хөтөлж, өөрийн сэтгэлийн дотоодод "тэмтрэгдэх" нэгэн нууцыг таньж мэдрэх хүслийг өдөөдөг. Тэмтрэгдэх - гэдэг үг бол түүний бүтээлд олонтаа тааралддаг, мэдрэхүйн амин утгыг агуулдаг шиг санагддаг. Орчлон харах мэлмий дутуу хүний тэмтрэх, баримжаалан мэдрэх чадвар нь илүү хөгждөг гэдэг дээ. Хүний нүд ертөнцийг тольдон гадагш харахаар заяасан хэдий ч эндээс зөвхөн өнгөн хальсыг олж харна, жинхэнэ мөн чанарыг танихын тулд өөрийнхөө дотоод оршихуй руу өнгийж байхыг буддизм сургадаг. Тиймдээ ч дотогшоо өнгийж сэтгэлийн */ертөнцийн/* жинхэнэ мөн чанарыг танихын анхны дасгал амьсгалаа мэдрэх бясалгал, иогоос эхэлдэг. Энэ бол хүний дотоод сэтгэлээ таних, өрөлх зөн, совин билгийн үүдээ нээх анхны алхам гэнэм.

Зохиолч Г.Аюурзанын ихэнх бүтээлийн гол дүрүүд /"Арван зүүдний өр"-ийн Тэнгис, "Бөөгийн домог"-ийн Хагдай бөө, "Цагаан хар улаан"-ны Рэнцэнраа<sup>9</sup>, "Судасны чимээ"<sup>10</sup>-гийн Алтан-Уул бариач, гм/ өөрт нь заяасан төрөлх зөн мэдрэмж нь энэ ертөнцийг нууцыг танихад хөтөлсөн совин билгийн хүч, нууцлаг далд өгүүлэмж ямагт гол шугамд нь байдаг. Товчхондоо, зохиолын гүн утга нь орчлон хийгээд хүмүүн-байгаль хоёрын нэгдэл, дээд оршихуйн холбоо буюу Буддын тантрын онолоор "бүхэл"-ийн тухай эргэцүүлэхэд хүргэдэг.

Нэгэнтээ зохиолчийн ҮГ-ийн тухай хөндсөнийх, нэг санаа нэмэхэд, шашин судлаач, орчуулагч П. Бадрал " Бодол, үг хүчтэй, заавал биеждэг жамтай" гэснийг хараад олзуурхав.

Ертөнцийн юмс бүхэн резонансад оршиж байдаг. Үг өөрөөсөө үл мэдэг долгион ялгаруулдаг гэж оккультизм үздэг. Энэ үнэхээр тийм гэж зөвшөөрмөөр боловч гаргаж ирээд харуул гэвэл бас л чадахгүй шүү дээ.

Үг бүр хүний /хүсэл, урам зориг /дотоод сэтгэлийн дуун илрэл. Зохиолч хүн бол тусдаа байгалиас тусгай өгөгдөлтэй төрдөг гэдэгтэй санал нийлнэ. Зохиолчийн бодолд буусан санаа бол чухамдаа дээд хүчин буюу чанадын оюун санааны цуурай байж болох бөгөөд тэдний төсөөлөлд биелэлээ олсон санаа үг болон бууж, бидний өмнө бодит дүр, цэвэр тодорхой дуу хоолой болж ирснээр оюун санааны гайхалтай бүтээлийг цогцлоон бүтээдэг. Тэрхүү үнэт бүтээл уншигчдын итгэл үнэмшил, сэтгэл догдлолтой нэгдэхээр улам биежиж /бидний/, өөрийн гэсэн тодорхой оршихуйг үүсгэж, огторгуйн хаа нэгтээ дээд түвшний долгион, оюунлиг орон зайд байр сууриа эзлэн оршин тогтнож эхэлдэг байж болох юм.

Ертөнцийн оюуны дээд хүчтэй бодол сэтгэлгээрээ нэгдсэн зохиолч, яруу найрагчийн зөн билэг бол тэдний оршин тогтнохын үндсийг улам бат бэх болгодог. Тэдний зөн билэг бол ертөнцийн мөн чанарыг танин мэдсний үр дүн, энгийн ахуйн үнэн, сэтгэхүй ухамсрын чанадад орших бодит мөн чанар<sup>11</sup> гэж Буддистууд үздэг.

Шүгдэн романы дундах очир алмаас мэт шигтгээ болон тод харагдах нэгээхэн хэсэг бол Саманд лам хайр харуусал хослосон дурлалын түүх байдаг. Бурхны номонд гүнзгий нэвтэрч, гуч гартлаа эмэгтэй хүнд дурлахын тухай төсөөлөл ч үгүй явсан Саманд, хувь тавилангийн егөө гэмээр хоромхон зуурын учралаар Дарамбалын

<sup>9)</sup> Г.Аюурзана (2014), "Цагаан хар улаан", Улаанбаатар.

<sup>10)</sup> Г.Аюурзана (2015), "Судасны чимээ", Улаанбаатар.

<sup>11)</sup> Буддын тантрын үндэс (2012), Улаанбаатар.

дүү бүсгүйд сэтгэл татагдах үест, хорвоогийн сайхныг мэдрэн дотогш бясалгах тэр агшин бол үнэндээ жинхэнэ Зэн оршихуй гэмээр. Буддын гэгээрсэн хутагтууд, сэтгэлээ танихуйн ухаанд суралцахын тулд эргэн тойрны үйл явдлыг энгүүн тайван ажигла гэж сургадаг. Ялангуяа сэтгэл ховсдох ийм үед үйл явдалд “оролцогч биш, ажиглагч бай” гэдэг. Багшийнхаа заасан номноос огтхон ч хазайж үзээгүй залуу хувраг Самандын энэ ертөнцийг орхихоос өмнө амжиж мэдэрсэн дурлалын гайхалтай мэдрэмж хийгээд орчлонгийн хоосон чанарыг оносон түүний сэтгэлээ танин барих чадвар, харуусал гуниг хослосон чин хайрын энэ түүх бол Шүгдэн романы хамгийн гэгээн хэсэг билээ.

Харин энэ бүхнийг өрнийн сэтгэл судлал, ялангуяа З.Фройдын дур хүслийн зарчим болоод ухамсаргүйн онолоор<sup>12</sup> тайлбарлах аргагүй. Түүний дэвшүүлсэн phallic symbol - шодойн бэлэгдэл, эсвэл Oedip complex Эдип маягийн / сэтгэцийн хүнд хэлбэрийн / согог-оор тайлбарлах нь эмгэг судлалы талаас ярьж болох зүйл боловч уран зохиол судлалд онцлон авч үзэхээргүйн дээр, өдгөө түүний энэ онол цагийн аясаар хуучирч бараг орхигдох тийшээ хандсан<sup>13</sup> гэсэнтэй санаа нийлдэг.

Шүгдэн романы өөр нэгэн мета өгүүлэмж бол тамын ертөнцөөр аялж буй Дарамбалын сүнс, хичнээн ертөнц, өчнөөн цаг хугацааг туулан эцэст нь өт хорхой болон төрж буй сонирхолтой хэсэг юм. Тамын болон засварын ертөнцөөр хоромхон зуур аялах тэрхүү аялал зохиолчийн төсөөллийн ертөнцийг тод харуулдаг.

Олон хэмжээст ертөнцийн тухай Буддизм тодорхой тайлбар байдаг. Эдгээрээс сүүлийн үед дэлхий олон оронд өөрийн номлолоо түгээж буй Японы шинэ шашны удирдагч, доктор Рьюхо Окава<sup>14</sup> номонд буддын шашин талаас нь тайлбарласан олон хэмжээс ертөнцийн тайлбар сонирхолтой. Тэрээр хүмүүн бид гурван хэмжээст ертөнцөд орших бөгөөд биднээс доош хоёр, нэг хэмжээст ертөнцөд там, бирдүүд, харин биднээс дээш дөрөв дэх хэмжээст ертөнцөд асурууд, түүнээс дээш 5, 6, 7 хэмжээст ертөнцөд илүү дээд оюунлиг сүнсний оршдог гээд 8-р ертөнцөд Татхагата нар байдаг гэдэг. Харин Буддистуудээс ялгаатай нь тэрээр, 10-13 дахь хэмжээст ертөнц байдаг гэж тодорхойлоод, түвшин дээшлэх тутам Мосе-гоос эхлээд Бурхан Багш, Есүс Христ гэх мэт хүн төрөлхтөний оюун ухааныг эзэмдэгч аугаа сүнснүүд мөнх оршоор байдаг гэж үздэг. Өөр нэг сонирхолтой мэдэгдэл нь 13 хэмжээст гариг эрхэс галактикийн оюуны ухааныг удирдан мөнхийн оршихуйг эзэмдэгч оюун ухаан тэнд оршдог гэдэг. (Рьюхо Окава, Ертөнцийн билгүүн оюуны, х-8.)

Шинжлэх ухааны үүднээс тайлбарлах боломжгүй уран зохиолын иррационал сэтгэлгээ, шашны ойлголт хийгээд ухамсарын бус зүйлс, тэдгээр нь зохиолчийн уран сайхны сэтгэлгээнд хэрхэн дүрслэгдсэнийг харьцуулах үүднээс дээрх санааг энд онцолсон болно.

### **Төгсгөлд нь: Мета өгүүлэмж ба “бүхэл”-ийн илэрхийлэл**

Оны эхэнд зохиолч Г.Аюурзана “судасны чимээ” романаа хэвлэгдэн гаргахын өмнөхөн Фэйсүүк хуудсандаа: “энэ тарнийн ачаар нэг ном бараг л бүтчихлээ шүү” гээд нэгэн тарнийн шившлэг бүхий зураг оруулсан байлаа. Тэр нь Энэтхэгийн нэгэн их иогч, бясалгал хийхдээ уншдаг тарни боллоотой. Энд тарнийн тухай өгүүлэхийн

<sup>12)</sup> Open Yale course (2009) ENGL-300: INTRODUCTION TO THEORY OF LITERATURE

<sup>13)</sup> Г.Билгүүдэй (2007), “Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм”, Улаанбаатар.

<sup>14)</sup> Ryuho Okawa (2005), “Ten principle of Universal Wisdom”, New York.

учир бол "үг долгион ялгаруулдаг" гэдэгтэй холбох гэснийх болой. Тарнийн бясалгалын гол үндэс мантра нь "ман"-сэтгэх, "тра"-үг бүтээгч зэмсэг<sup>15</sup> гэсэн хоёр үгээс бүтдэг гэнэм.

Зохиолчийн сэтгэлд боловсорч, ур ухаанаар эвцэлдүүлж бүтсэн үг, тарнийн хүчээр илүү увидас шингээдэг байж магадгүй юм хэмээн Буддын тантрын үндсийг унших зуураа мунхаглан бодов.

Мантра бол зүгээр нэг ердийн үг биш аугаа их хүчний мөн чанар бөгөөд тэр нь оршин буй бүхнийг өөрийн дуу авиагаараа илэрхийлдэг. ҮГ өөр хаана ч биш гагцхүү энд л шууд үйл болон илэрдэг гэх агаад жинхэнэ найрагч, зохиолчийн үг бодот ертөнцийн үнэнийг бүтээж, түүнийг танин мэдэхэд уриалж, бодит боломжийг нээдэгт тэдгээрийн хүч чадал нь оршдог. Тэдний үг зүгээр хүүрнэх төдий бус, харин нөлөө үзүүлж байдаг гэж тэртээ 1930 онд Зиммер<sup>16</sup> бичжээ.

Энд өгүүлэн буй мантра, тарни, метафизик, олон хэмжээст ертөнц, орчлонгийн хоосон чанарыг онож танихын урьдал болдог бясалгал, амьсгал, Зэн оршихуй бүгд нийлээд Буддизм, бүгдээрээ дорнын сэтгэлгээний цогц хэлбэрүүд бөлгөө. Гэвч дорныхны дотогшоо хэтийдсэн, өрнийнх гадагшаа хэлбийсэн хандлагын аль аль нь жам ёсноос хазайсан хөгжлийн гажилт гэж үздэгийг ч тэмдэглэх хэрэгтэй. "Аль нэг тийшээ хэлбийсэн хөгжил бол өрөөсгөл. Дэлхий ертөнц нэгэн бүхэл, хүн төрөлхтөн нэг л гэр бүл. Тиймээс гадаад ба дотоод аль алинд нь ч туйлшралгүй нэгэн бүхэл ...<sup>[...]</sup> оршихуйн тухайд авч үзэх нь чухал. Хайр бол гадагшаа гарах гарц, бясалгал бол дотогшоо нэвтрэх орц, хайр бясалгал хоёрыг хамтад нь заадгийн учир энэ"<sup>17</sup> гэсэн 20 зууны хамгийн тод гэгээрсэн багш, аугаа мистикч Ошо бээр тайлбараар энэхүү өгүүллээ өндөрлөө.

## НОМ ЗҮЙ

1. Аюурзана Г.(2012) "Шүгдэн", Улаанбаатар.
2. Аюурзана Г. (2014) "Цагаан хар улаан", У Улаанбаатар.
3. Аюурзана Г. (2015) "Судасны чимээ", Улаанбаатар.
4. Агнистын гэгээ-9, (2012) "Очироор огтлогч". Улаанбаатар.
5. Буддын тантрын үндэс (2012), Улаанбаатар.
6. Билгүүдэй Г. (2007), Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм, Улаанбаатар.
7. Билигсайхан Ч. (2003), "Ухаарахуй", Улаанбаатар.
8. Карл Густав Юнг, "О психологии восточных религий и психологий".
9. Карл Густав Юнг, "Бэлэгдэл амьдрал".
10. <http://en.wikipedia.org/wiki/Metaphysics>
11. Open Yale course (2009) ENGL-300: INTRODUCTION TO THEORY OF LITERATURE.
12. Ryuho Okawa. (2005), Ten principle of Universal Wisdom New York.

<sup>15</sup>) Буддын тантрын онол (2012), Улаанбаатар.

<sup>16</sup>) Буддын тантрын үндэс (2012), Улаанбаатар.

<sup>17</sup>) Агнистын гэгээ-9 (2012), Очироор огтлогч, Улаанбаатар. 126-р тал.